# ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

facebook.com/Rtcc.m0n
http://rtcc.mrtd.gov.mn
info@rtcc.mrtd.gov.mn
+976 77244409

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

2024 оны 04 дугаар сарын дугаар

## Төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд:

АНУ, Канад, БНХАУ, Австрали, Энэтхэг тэргүүтэй 30 гаруй улсад RFID системийг ашиглаж байна. 2023 оны статистикаас харвал дэлхийн төмөр замын салбарт 10 сая шошго, +38,000 уншигч ашиглаж байна. БНХАУ-ын Харибины төмөр замын судалгааны инистутут 1 сая шошго, 10 мянган уншигч, АНУ, Канадын төмөр зам нь энэ системээр 3,2 сая вагон тоноглож, 20 000 шошго уншигч суурилуулсан байна. ОХУ-д зүтгүүрийн 100%, зорчигчийн вагоны 10%, ачааны вагоны 42%, моторт вагоны 89% нь уг төхөөрөмжөөр тоноглогдсон байна.



## "Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээний нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна.

Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлж төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна. Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээллийн санд хоногийн 600 мэдээ, сарын 48 мэдээг бүрдүүлж мэдээллийн нэгдсэн санд байршиж байна. ЗТХ-ийн сайдын 2020 оны А/154 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам”, ЗТХ-ийн 2021 оны “Зам, тээврийн салбарын статистикийн мэдээлэл авах, мэдээллийн сан бий болгох заавар, маягт, нөхөх заавар, үзүүлэлт батлах тухай” А/93 дугаар тушаалын хүрээнд ЗТХЯ-нд сарын статистик мэдээг албан бичиг болон цахим шуудангаар хүргэж тайлагнасан. Суурь бүтэц эзэмшигчийн тээвэрлэсэн ачааны хэмжээ (импорт, экспорт, дамжин өнгөрсөн, орон нутаг-тонн), чингэлэг тээвэрлэлт (импорт, экспорт, орон нутаг, транзит-тонн), зорчигч тээвэрлэлт (олон улс, орон нутаг-хүн) 2024 оны 03 дугаар сарын ачаа тээврийн статистик мэдээг нэгтгэн болосруулж 2024 оны 04 дугаар сарын 20-ний өдөр төвийн цахим хуудас, олон нийтийн сүлжээнд байршуулж мэдээлсэн.



## Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, тайлан мэдээг танилцуулах




2024 оны 03 дугаар сарын тасалдалд дүн шинжилгээ хийж, тайланг 2024 оны 04 дүгээр сарын 08-ний өдрийн 265 дугаарын албан бичгээр СХГ-д танилцуулсан. 2024 оны I улирлын тасалдалд дүн шинжилгээ хийж, тайланг 2024 оны 04 дүгээр сарын 08-ний өдрийн 266 дугаарын албан бичгээр СХГ-д танилцуулсан. 2024 оны I улирлын осол, гологдлын тайланг 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 272 дугаарын албан бичгээр СХГ-д танилцуулсан. Нэгдсэн зурмагийн 2024 оны 1 улирлын гүйцэтгэлд дүн шинилгээ хийж, тайланг суурь бүтэц эзэмшигчдэд 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 281,282,283,284,285 дугаарын албан бичгээр танилцуулан, албан даалгавар өгч, ТЗДТБЗГ-д 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 308 дугаарын албан бичгээр танилцуулсан. Хилийн болон суурь бүтэц хоорондын солилцоо, тасалдал, экспортын ачааны инфографик мэдээг 2024 оны 04 дүгээр сарын 01, 16-ны өдрүүдэд гарган, удирдлагад танилцуулсан. Суурь бүтцүүдээс ирүүлсэн мэдээг нэгтгэн, хоногт тээвэрлэсэн ачааны мэдээг өдөр бүр, мидлинг тээврийн мэдээг 7 хоног бүр гарган ажилласан.




2024 оны зуны цагийн нэгдсэн хөдөлгөөний зурмагийг 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр батлуулан, суурь бүтэц эзэмшигч нарт 312,313,314,315,316 дугаарын албан бичгээр хүргүүлсэн.

## Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас:




Ачааны галт тэрэгт хоорондын замд аялах явцад үүсэх чичиргээний зонхилох давтамжийг тодорхойлж тус давтамжид үндэслэн хөдөлгөөний аюулгүй байдлын бичил мэдрэгч, системүүдийг тэжээх боломжийн судалгаа, туршилт”-ыг I-р зэрэглэлийн төмөр замд туршихтай холбоотой ТТЗ ХХК-аас ажлын хэсэгт орж ажиллах 3 албан хаагчдын нэрсийг 2024.04.09-ны өдөр 1/960 тоот албан бичигээр ирүүлсэн. ГТХЗНТ-3, ШУТИС-МХТС - 2, ТТЗ ХХК-3 албан хаагчдаас бүрдсэн ажлын хэсгийн тушаал болон удирдамжийг боловсруулан батлуулахаар "төв"-ийн захиралд танилцуулаад байна.Төвийн Цахим хөтөлбөр хариуцсан мэргэжилтэнтэй хамтран 2024.04.15-ны өдөр ШУТИС-МХТС-ийн багшай уулзаж туршилтыг ирэх 5 дугаар сарын эхний хагаст хийж гүйцэтгэхээр тохиролцсон. “ТТЗ“ ХХК-ны Ерөнхий инженер болон ажлын хэсэгт орж ажиллах албан хаагчдад туршилт хийхээр төлөвлөж буй хугацааны талаар мэдэгдээд байна. STLIS3DH маркийн чичиргээ хэмжих төхөөрөмжид нэмэлтээр бодит цагийн (RTC) модуль суурилуулах болон галт тэрэгний хурдыг тооцож өгөгдөлд нэгтгэх, эх код хөгжүүлэлт, сайжруулалтын ажлыг гүйцэтгэх зэрэг ажлуудын лабораторийн орчинд туршин ажиллаж байна.

Радио давтамж тодорхойлогч (RFID - Radio Frequency Identification) технологийн үндсэн ойлголт, ажиллах зарим болон танилт илрүүлэлтийн хувийг агуулсан Зурган постер бүтээн, тайлбарын хамт төвийн цахим хуудас болон нийтйин сүлжээнд байршуулан сурталчилан ажиллаж байна.









## “Монгол улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд шинээр дугаар олгох, баталгаажуулах, мэдээллийн санд бүртгэх, ЗТХЯ-ыг мэдээллээр хангах” ажлын хүрээнд:



“Аксис оф ворлд” ХХК-ийн 100, “Монголиантранс ложистик” ХХК-ийн 200, “Ворлд энтри транспортс” ХХК-ийн 200, “Монцемент билдинг материалс” ХХК-ийн 40, нийт 540 ачааны хагас вагонд шинээр дугаар олгож, “Дулаан винг” ХХК-ийн ачааны хагас 2 вагон, “ХалиунУул” ХХК-ийн 10 зерновез вагон, “Тонж логистик” ХХК-ийн ачааны 23 хагас вагон, 7 битүү вагон, “Бэст даймонд” ХХК-ийн ачааны 1 хагас вагон, “ТТЗ” ХХК-ийн 2 зүтгүүр, нийт түрээсийн 45, бүгд 585 хөдлөх бүрэлдэхүүнийг мэдээллийн санд бүртгэж, “Смарт деливери монголиа” ХХК-д олгосон ачааны 100 хагас вагон, “Ла маккина плаза” ХХК-д олгосон ачааны 200 хагас вагоны дугаарыг хүчингүй болсонд тооцож, “Бэст даймонд” ХХК-ийн ачааны 1 хагас вагон, “Тонж логистик” ХХК-ийн 106 цистерн вагоны мэдээллийг хөдлөх бүрэлдэхүүний мэдээллийн сангаас хассан.



## Төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд:

Төслийн хүрээнд Баянгол дүүргийн 20-р хороонд шинээр баригдах барилгын "Шав тавих ёслол"-ыг 2024.04.12-ны өдөр зохион байгуулсан. Тус ёслолын үйл ажиллагаанд ЗТХЯ-ны дэд сайд, хэлтсийн дарга, “КОЙКА“ ОУХАБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч, төмөр замын суурь бүтэц эзэмшигч байгууллагуудын төлөөлөл болон “ГТХЗНТ“ УТҮГ-ын захирал, албан хаагчид, “Мандал констракшин“ ХХК-ны албан хаагчид зэрэг нийт 40 орчим хүн оролцсон.







“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн барилга барих, үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх замаар Монгол Улсын төмөр замын тээврийн өрсөлдөх чадварыг сайжруулах төсөл” нь БНСУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламж болон Монгол Улсын улсын төсвийн хөрөнгөөр санхүүжиж буй юм.

Энэхүү төсөл хэрэгжсэнээр хөрш орнуудын болон суурь бүтэц хоорондын төмөр замын тээвэрлэлтийн хэмжээ, галт тэрэг солилцох үйл ажиллагаанд төрийн зүгээс хяналт тавьж, тээврийн төлөвлөлт - эдийн засгийн үр ашигтай байдлын уялдааг хангаж, одоо үйл ажиллагаа явуулж байгаа болон ирээдүйд баригдах өмчийн олон төрөл, хэлбэрийн төмөр замуудын галт тэрэгний хөдөлгөөнийг нэгдсэн удирдлагаар хангах нөхцөл бүрдэж буй томоохон ач холбогдолтой.








Газар бизнес төвийн байр,
Тээвэрчдийн гудамж,
2-р хороолол, 1-р хороо,
Баянгол дүүрэг, 16052,
Улаанбаатар хот, Монгол улс